

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР




САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/116/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр 2022 он	Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Аудитор: Р.Энхзул Утас: 70323833 Цахим хаяг: EnkhzulR@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
- 3.1 Ерөнхий зүйл
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Материаллаг байдал.....
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

СТАНДАРТ, ХЭМЖИЛ
ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.МӨНХТӨР ТАНАА

2022.02.25 № 237
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

015030673

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,817,219.00	9,028,800.00
33	АВЛАГА	747,619.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	747,619.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	4,069,600.00	9,028,800.00
354	Хангамжийн материал	4,069,600.00	9,028,800.00
35410	Бичиг хэргийн материал	335,250.00	273,450.00
35420	Аж ахуйн материал	3,691,350.00	8,079,350.00
35430	Сэлбэг хэрэгсэл	43,000.00	676,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	150,194,907.37	134,041,695.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	150,194,907.37	134,041,695.18
392	Биет хөрөнгө	105,774,907.37	89,621,695.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	85,659,187.15	76,412,420.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(41,682,720.91)	(34,646,383.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	52,200,000.00	52,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,533,333.36)	(25,533,333.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	114,741,890.00	115,541,890.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(89,300,389.72)	(96,220,989.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,884,358.03	7,654,358.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,279,730.68)	(5,786,266.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	904,721.34	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	(819,074.48)	-
393	Биет бус хөрөнгө	44,420,000.00	44,420,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	44,420,000.00	44,420,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	155,012,126.37	143,070,495.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	747,619.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	747,619.00	-
413	Өглөг	747,619.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	747,619.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	154,264,507.37	143,070,495.18
51	Засгийн газрын хувь оролцоо	154,264,507.37	143,070,495.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	64,912,371.00	64,912,371.00
51101	Өмч: - төрийн	64,912,371.00	64,912,371.00
512	Хуримтлагдсан үр дүн	77,204,370.64	78,158,124.18
51210	Өмнөх үеийн үр дүн	77,204,370.64	89,352,136.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	(11,194,012.19)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,147,765.73	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	155,012,126.37	143,070,495.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	372,805,734.10	216,255,590.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	226,178,315.00	59,768,390.00
120	Нийтлэг татварын бус орлого	226,178,315.00	59,768,390.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	226,178,315.00	59,768,390.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,309,265.00	57,266,940.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө	153,268,900.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал	1,600,150.00	2,501,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,627,419.10	156,487,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	149,487,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	149,487,200.00

Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,638,419.10	7,000,000.00
131103	ЗГНХ ЗДНХөрсөнгө, түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,900,000.00	7,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,738,419.10	-
1330	Төсвийн захирагчдаас	123,989,000.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	123,989,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	235,295,456.87	224,886,352.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,295,456.87	224,886,352.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	227,866,635.87	216,889,090.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	131,229,788.00	136,233,218.00
210101	Үндсэн цалин	100,242,145.00	94,048,394.00
210102	Нэмэгдэл	25,966,143.00	34,838,387.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,021,500.00	7,346,437.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,344,748.10	18,403,600.00
210201	Тэтгэврийн даатгал	12,241,848.10	12,950,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,275,700.00	1,363,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,020,600.00	1,090,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	255,100.00	272,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,551,500.00	2,726,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,972,564.00	12,454,720.00
210301	Гэрэл, цахилгаан	542,784.00	483,390.00
210302	Түлш, халаалт	11,275,000.00	11,547,610.00
210303	Цэвэр, бохир ус	154,780.00	423,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,500,000.00	8,029,500.00
210401	Бичиг хэрэг	1,600,000.00	1,193,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,616,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	2,091,374.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	2,067,826.00
2105	Нормативт зардал	100,000.00	1,220,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	1,220,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,800,000.00	7,739,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	367,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	372,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	7,000,000.00
2107	Томиллолт, зочны зардал	9,874,927.00	6,600,000.00
210702	Дотоод албан томиллолт	9,874,927.00	6,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,353,100.00	6,595,840.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,400,000.00	4,860,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,600.00	208,640.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	82,500.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	330,000.00	330,000.00
210807	Газрын төлбөр	-	444,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	610,000.00	448,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,691,508.77	19,613,212.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	490,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,291,508.77	17,723,212.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,428,821.00	7,997,262.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	480,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	480,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,528,821.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,517,262.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,517,262.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	137,510,277.23	(8,630,762.19)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,264,900.00	2,563,250.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,264,900.00)	(2,563,250.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	136,245,377.23	(11,194,012.19)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	64,912,371.00	12,147,765.73	-44,361,006.59	00.00	32,699,130.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,912,371.00	12,147,765.73	-44,361,006.59	00.00	32,699,130.14
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	136,245,377.23	00.00	136,245,377.23
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,912,371.00	12,147,765.73	77,204,370.64	00.00	154,264,507.37
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	64,912,371.00	12,147,765.73	77,204,370.64	00.00	154,264,507.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	12,147,765.73	00.00	12,147,765.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,912,371.00	12,147,765.73	89,352,136.37	00.00	166,412,273.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-12,147,765.73	00.00	00.00	-12,147,765.73
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,194,012.19	00.00	-11,194,012.19
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,912,371.00	00.00	78,158,124.18	00.00	143,070,495.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	217,936,684.10	213,754,140.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,309,265.00	57,266,940.00
120	Нийтлэг татварын бус орлого	71,309,265.00	57,266,940.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	71,309,265.00	57,266,940.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,309,265.00	57,266,940.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,627,419.10	156,487,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	149,487,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	149,487,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,638,419.10	7,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,900,000.00	7,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,738,419.10	-
1330	Төсвийн захирагчдаас	123,989,000.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	123,989,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	203,476,684.10	212,184,140.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	203,476,684.10	212,184,140.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	196,047,863.10	204,186,878.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	131,229,788.00	136,233,218.00
210101	Үндсэн цалин	100,242,145.00	94,048,394.00
210102	Нэмэгдэл	25,966,143.00	34,838,387.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,021,500.00	7,346,437.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,344,748.10	18,403,600.00
210201	Тэтгэврийн даатгал	12,241,848.10	12,950,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,275,700.00	1,363,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,020,600.00	1,090,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	255,100.00	272,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,551,500.00	2,726,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,000,000.00	12,454,720.00
210301	Гэрэл, цахилгаан	542,784.00	483,390.00
210302	Түлш, халаалт	12,302,436.00	11,547,610.00
210303	Цэвэр, бохир ус	154,780.00	423,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,500,000.00	8,029,500.00
210401	Бичиг хэрэг	1,600,000.00	1,193,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,616,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	2,091,374.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	2,067,826.00
2105	Нормативт зардал	100,000.00	1,220,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	1,220,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,240,000.00	10,040,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	440,000.00	1,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	1,440,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	7,000,000.00

Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	11,880,227.00	6,600,000.00
210702	Дотоод албан томилолт	11,880,227.00	6,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	7,353,100.00	8,215,840.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,400,000.00	6,480,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,600.00	208,640.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	82,500.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	330,000.00	330,000.00
210807	Газрын төлбөр	-	444,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	610,000.00	448,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	2,990,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,730,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	1,260,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,428,821.00	7,997,262.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	480,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	480,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,528,821.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,517,262.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,517,262.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,460,000.00	1,570,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,460,000.00	1,570,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,460,000.00	1,570,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,460,000.00	1,570,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,460,000.00	1,570,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(14,460,000.00)	(1,570,000.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	199,487,200.00	199,236,878.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	199,487,200.00	199,236,878.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	199,007,200.00	198,756,878.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	136,323,600.00	136,233,218.00
210101	Үндсэн цалин	103,015,400.00	94,048,394.00
210102	Нэмэгдэл	29,150,200.00	34,838,387.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,158,000.00	7,346,437.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,403,600.00	18,403,600.00
210201	Тэтгэврийн даатгал	12,950,700.00	12,950,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,363,200.00	1,363,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,090,600.00	1,090,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	272,600.00	272,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,726,500.00	2,726,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,524,000.00	12,454,720.00
210301	Гэрэл, цахилгаан	1,560,000.00	483,390.00
210302	Түлш, халаалт	9,924,000.00	11,547,610.00
210303	Цэвэр, бохир ус	1,040,000.00	423,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,029,500.00	8,029,500.00
210401	Бичиг хэрэг	1,316,000.00	1,193,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,857,500.00	2,616,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,820,000.00	2,091,374.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,876,000.00	2,067,826.00
2105	Нормативт зардал	1,220,000.00	1,220,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,220,000.00	1,220,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,840,000.00	3,840,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,400,000.00	2,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,440,000.00	1,440,000.00

Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	6,600,000.00	6,600,000.00
210702	Дотоод албан томилолт	6,600,000.00	6,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,306,500.00	8,215,840.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,480,000.00	6,480,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	231,800.00	208,640.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	82,500.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	330,000.00	330,000.00
210807	Газрын төлбөр	444,200.00	444,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	40,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	448,000.00	448,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,760,000.00	3,760,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,260,000.00	1,260,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	480,000.00	480,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	480,000.00	480,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	480,000.00	480,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	199,487,200.00	199,236,878.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	149,487,200.00	141,969,938.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	149,487,200.00	141,969,938.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	50,000,000.00	57,266,940.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000,000.00	57,266,940.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		7,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,000,000.00
210604	Урсгал засвар		7,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	7,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		7,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Энхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймгийн Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь 2021 онд “Орон нутагт үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд хэрэглэгчдийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх” зорилго тавьсан бөгөөд “Стандартчилал, хэмжилзүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын 2018 оны А/06, 2021 оны 10 сарын 04 –ний өдрийн А/09 дугаар тушаалаар байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгжийг 4 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг уг тушаалын хавсралтаар баталж мөрдөн ажиллаж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 224886.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2248.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувь буюу 1799.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 1570.0 мянган төгрөгөөр өссөн нь 800.0 мянган төгрөгийн принтер, 770.0 мянган төгрөгийн ширээ худалдан авсантай холбоотой. ТӨБЗГ-ын тогтоолоор нийт 10151.5 мянган төгрөгийн барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгө акталсан байна.
- Бараа материал оны эхнээс 4959.2 мянган төгрөгөөр өссөн нь худалдаж авсан аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 331213.4 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 205449.7 мянган төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсөв 205449.7 мянган төгрөгөөр батлагдаж, тодотголоор 5962.5 мянган төгрөгөөр хасагдаж 199487.2 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн ба үүнээс 7517.3 мянган төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлжээ. Тайлант оны нийт төсвийн гүйцэтгэл 191969.9 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын захирамжаар 7000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэн урсгал засварын зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэхэд шинээр 200.0 мянган төгрөгийн албаны болон ажлын хувцас худалдан авсан зөрчил илэрлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 140 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 200.0 мянган төгрөгийн алдаа илэрсэн.

4.1 Залруулга

Залруулга байхгүй

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

Шинээр 200.0 мянган төгрөгийн албаны болон ажлын хувцас худалдан авсан зөрчилд албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	1	200.0					1	200.0		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Р.ЭНХЗУЛ

